



ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 22, өдөр

Дугаар A/151


Улаанбаатар хот

Г Шударга байдлын хороо байгуулах, ажиллах журам батлах тухай

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.5, Засгийн газрын 2018 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний итгэмжлэлийн төв”-ийн дүрмийн 4 дүгээр бүлгийн 4.4.6 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн итгэмжлэлийн үйл ажиллагааны шударга байдлын эрсдлийг тодорхойлох, хяналт тавих чиг үүрэг бүхий “Шударга байдлын хороо”-ны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Шударга байдлын хорооны ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Шударга байдлын хорооны үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын албаны дарга Захиргаа, удирдлагын газарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.СОРОНЗОНБОЛД

Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын
2021 оны 06 дүгээр сарын 22-ны өдрийн
A/151 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Шударга байдлын хорооны ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагын үйл ажиллагааны бодиттой, шударга байдалд нь хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Шударга байдлын хорооны үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Шударга байдлын хороо нь үйл ажиллагаанд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, MNAS P 403 Шударга байдлын журам болон энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1 Шударга байдлын хороог Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын тушаалаар томилсон дарга тэргүүлэх ба хорооны нарийн бичгийн даргын үргийг Үндэсний итгэмжлэлийн төвийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /орон тооны ажилтан/ гүйцэтгэнэ.

2.2 Шударга байдлын хорооны бүрэлдэхүүнд MNS ISO/IEC 17011:2018 “Тохирлын үнэлгээ. Тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх итгэмжлэлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага” стандартын 4.4.5-д заасны дагуу тохирлын үнэлгээний байгууллагын төлөөлөл (2 хүн), удирдах зөвлөлийн төлөөлөл (1 хүн), итгэмжлэлийн техникийн хорооны төлөөлөл (1 хүн), их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдын төлөөлөл (2 хүн), итгэмжлэлийн байгууллагын (1 хүн) төлөөлөл орсон байна.

Гурав. Хорооны гишүүнд тавих ерөнхий шаардлага

3.1 Хорооны гишүүн нь магистрын түвшинээс дээш боловсролын зэрэгтэй, эрсдлийн удирдлагын чиглэлээр зохих мэдлэгтэй, туршлагатай байх, хорооны гишүүн байхад ашиг сонирхол үүсгэхгүй байх, төлөөлж буй сонирхогч талын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх.

3.2 Сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын холбогдох стандарт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үндэсний болон олон улсын итгэмжлэлийн тогтолцооны дүрэм, журам, стандартын мэдлэгтэй байх.

3.3 Шударга, харилцааны өндөр соёл, чадвартай байх.

Гурав. Шударга байдлын хорооны эрх

- 3.1** Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагаа нь хууль, тогтоомж, олон улсын стандарт, дүрэм журамд заасан шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар жилд нэгээс доошгүй удаа эрсдэл, шударга байдлын талаар үнэлгээ хийх;
- 3.2** Шударга байдлын түвшин, эрсдлийн үнэлгээнд шаардлагатай баримт бичиг, материал, мэдээлэл, судалгаагаар хангагдах, итгэмжлэлийн газар дээрх үнэлгээнд ажиглагчаар ажиллах;
- 3.3** Эрсдэл, шударга байдлын чиглэлээр хийж байгаа ажлын үр дүнг хэлэлцэж, чиглэл, удирдамж өгөх;
- 3.4** Олон улсын болон бус нутаг, гадаад орны холбогдох байгууллагаас зохиогдох арга хэмжээнд эрхэлсэн асуудлынхаа хүрээнд оролцох.

Дөрөв. Шударга байдлын хорооны үүрэг

- 4.1** Холбогдох хууль, дүрэм, суурь стандартыг удирдамж болгон мөрдөх;
- 4.2** Итгэмжлэлийн үйл ажиллагаанд үндэсний итгэмжлэлийн байгууллагаар дамжуулан санал, чиглэл өгөх, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 4.3** Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хэтийн чиглэл, хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, төлөөлсөн салбарын бодлогыг тусгуулах, зохицуулалт хийх;
- 4.4** Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагааны мэдээ тайлантай танилцах, холбогдох байгууллагуудаас судалгаа гаргуулан, дүгнэлт гаргах, чиглэл өгөх;
- 4.5** Аль нэг байгууллага, иргэний явцуу эрх ашгийг хамгаалахгүй, ашиг сонирхлын зөрчилгүй байх.
- 4.6** Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 27, 28-р зүйл, итгэмжлэлийн холбогдох дүрэм журмын дагуу нууцыг хадгалах тухай мэдэгдэл гаргасан байна.

Тав. Шударга байдлын хорооны хуралдаан

- 5.1** Шударга байдлын хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг Шударга байдлын хорооны дарга үндэсний итгэмжлэлийн байгууллагын саналыг үндэслэн зарлан хуралдуулна.
- 5.2** Хуралдааны дэгийг Шударга байдлын хороо батална. Шударга байдлын хорооны хуралдааны шийдвэр нь зөвлөмж байна.
- 5.3** Шударга байдлын хорооны ээлжит хуралдааныг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

5.4 Ээлжит хуралдааны товыг хуралдаан болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хуралдааны материалыг тараасан байна.

5.5 Шударга байдлын хорооны хуралдааныг гуравны хоёр буюу түүнээс дээш гишүүд оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд талууд тэнцвэртэй байх ёстой. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхын саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

Зургаа. Шударга байдлын хорооны нарийн бичгийн даргын чиг үүрэг

6.1 Шударга байдлын хорооны нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1 Шударга байдлын хорооны хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тэмдэглэл хөтөлж, хуралдааныг зохион байгуулах;

6.1.2 Шударга байдлын хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад гишүүдээс гадна бусад холбогдох талуудыг татан оролцуулах, хяналт тавих;

6.1.3 Шударга байдлын хороонд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, Шударга байдлын хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;

6.1.4 Шударга байдлын хорооны хуралдааны шийдвэрийг Итгэмжлэлийн байгууллагад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж тайлagnaх;

6.1.5 Шударга байдлын хорооноос зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

6.1.6 Шударга байдлын хорооны үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах;

6.1.7 Шударга байдлын хорооны үйл ажиллагааг төлөвлөх, тайлagnaх.

6.1.8 Шударга байдлын хорооны архив, бичиг хэргийг хөтлөн явуулна.

Долоо. Бусад

7.1 Шударга байдлын хорооны даргаас гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж, гишүүдийн ажлын оролцоог дүгнэн, урамшуулалт олгоно.

7.2 Шударга байдлын хорооны үйл ажиллагааны зардлыг тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал хариуцсан байгууллагын төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.